



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2020 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

Хяналтын төрийн бус байгууллага  
ажиллуулах тухай


Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2019 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр хурлын тэмдэглэл, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 3.1.5, 3.1.14 дэх хэсэг, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн зөвлөлийн хурлын 2019 оны 21 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын гудамж, зам талбайн хог хаягдал, цас, мөсний цэвэрлэгээ, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын ангилан ялгалт, ачилт, цуглуулалт, тээвэрлэлт, төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагаа, эзэнгүй нохой, муурны устгал, гэр хорооллын айл өрхийн нохой бүртгэлжүүлэлт, Улаанбаатар хотын бохирдол ихтэй гудамж талбайн ариутгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагаанд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албыг төлөөлж, тухай бүр хяналт тавьж ажиллах төрийн бус байгууллага, тэдгээрийн хариуцах нутаг дэвсгэрийн хуваарийг 1 дүгээр, хяналтын ажилд шаардагдах төсвийн задаргааг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай

2. Тушаалын хавсралтад дурдсан төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж, гэрээний хэрэгжилт, ажлын гүйцэтгэлд тухай бүр хяналт тавьж ажиллахыг Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтэс /С.Аригуун/-т даалгасугай.

3. Хот нийтийн аж ахуйн 2020 оны дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу хяналтын төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийж ажиллахыг Дотоод хяналтын хэлтэс /Ц.Рэгээдмаа/-т үүрэг болгосугай.

4. Хяналтын үйл ажиллагаанд шаардагдах 533,665,654.00 ₮ /Таван зуун гучин гурван сая зургаан зуун жаран таван мянга зургаан зуун тавин дөрөв/ төгрөгийг энэхүү тушаалын хавсралтад заасны дагуу хот нийтийн тохижилт, үйлчилгээний холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР




Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
 2020 оны *дугаар* сарын *14* өдрийн  
*А/ос* тушаалын *дугаар* хавсралт



ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН 2020 ОНД  
 ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД,  
 ТЭДГЭЭРИЙН ХАРИУЦАХ НУТАГ ДЭВСГЭРИЙН ХУВААРЬ

Д/д	Хяналт тавих байгууллага	Хариуцах нутаг дэвсгэр	Хяналт тавих ажлын чиглэл
1	Хотын хөгжлийг дэмжих Улаанбаатар шинэ тосгон хөдөлгөөн ТББ	Сонгинохайрхан дүүрэг Чингэлтэй дүүрэг	<ul style="list-style-type: none"> <li>Зам талбайн цэвэрлэгээ</li> <li>Хог хаягдлын ангилан ялгалт, ачилт, цуглуулалт, тээвэрлэлт</li> </ul>
2	Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэн ТББ	Баянзүрх дүүрэг Хан-Уул дүүрэг	<ul style="list-style-type: none"> <li>Гудамж зам талбайн ариутгал</li> </ul>
3	Эмэгтэйчүүдийн эрх хамгаалал хөгжлийн хүрээлэн ТББ	Баянгол дүүрэг Сүхбаатар дүүрэг	<ul style="list-style-type: none"> <li>Хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ</li> </ul>
4	Бид туслая ТББ	Хотын 3 төвлөрсөн хогийн цэг	<ul style="list-style-type: none"> <li>Золбин нохой, муурны устгал</li> <li>Устгасан нохой муурны сэг зэмийг шатаах, булах үйл ажиллагаа</li> <li>Гэр хорооны айл өрхийн нохой бүртгэлжүүлэлт</li> <li>Төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагаа,</li> <li>Төвлөрсөн хогийн цэг дэх ариутгал</li> </ul>

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
 2020 оны 01 сарын 14 өдрийн  
 708 тушаалын хавсралт



ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН  
 2020 ОНД ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХ  
 АЖЛЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА

Д/д	Төсвийн хуваарилалт	Нийт зардал	Захиалагчийн хяналт 12%/
1	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт олон жил хуримтлагдсан хур хог хаягдлыг цэвэрлэж, дахин үүсэхгүй байх арга хэмжээг авах	200,000,000.0	4,000,000.0
2	Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ	17,228,487,840.0	344,569,756.8
3	Иргэдийн бүлгийн цэвэрлэгээний зардал	803,000,000.0	16,060,000.0
4	Төвлөрсөн хогийн цэгийг хөрсөөр дарж булах үйл ажиллагааг технологийн дагуу хийх	2,080,000,000.0	41,600,000.0
5	Эзэнгүй нохой, муур устгах	1,200,000,000.0	24,000,000.0
6	Гэр хорооллын айл өрхийн нохойг бүртгэлжүүлэх	493,350,000.0	9,867,000.0
7	Устгасан золбин нохой, муурын сэг зэмийг шатаах, дарж булах зардал	54,650,000.0	1,093,000.0
8	Хогийн төвлөрсөн цэгүүдийн ариутгал	200,000,000.0	4,000,000.0
9	Хөрсний бохирдол бууруулах төсөл арга хэмжээний зардал	370,000,000.0	7,400,000.0
10	Алтан өлгийн оршуулгын газрын арчлалт хамгаалалтын зардал	88,735,225.0	1,774,704.5
11	Нийтийн бие засах газрын ашиглалтын болон ажилчдын зардал	126,540,000.0	2,530,800.0
12	Гэр хороолол, орон сууцны хорооллын доторх зэрлэг ургамлын устгал	200,000,000.0	4,000,000.0
13	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн тоосжилтыг бууруулах зорилгоор зам талбай, агаар чийгшүүлэх, автозам тусгаарлах шар хайс угаах	195,449,600.0	3,908,992
14	Зөвшөөрөлгүй оршуулсан шарилыг нүүлгэж шилжүүлэх, чандарлах зардал	151,500,000.0	3,030,000.0
15	Био 00-н үйлчилгээний зардал	179,100,000.0	3,582,000.0
16	Төвлөрсөн хогийн цэгийн ландфилийн талбайг хэсэгчлэн хаах	2,912,470,052.0	58,249,401.0
17	Айл өрх аж ахуйн нэгжийн хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах системийг 3 хороонд нэвтрүүлэх	200,000,000.0	4,000,000.0
	<b>Нийт дүн</b>	<b>26,683,282,717</b>	<b>533,665,654</b>